МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 20 өдөр Дугаар А/453 Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 3.4, аймгийн Онцгой комиссын 2022 оны 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 09 дүгээр сард Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Чулуут ууланд гарсан ой хээрийн түймрийг унтраахад гарсан зардалд 4,321,300 (Дөрвөн сая гурван зуун хорин нэгэн мянга гурван зуу) төгрөг, Цагааннуур сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэр Моорог ууланд гарсан ой, хээрийн түймрийг унтраахад гарсан зардалд 7,710,200 (Долоон сая долоон зуун арван мянга хоёр зуу) төгрөг, Онцгой байдлын ерөнхий газраас Хөвсгөл аймагт зохион байгуулсан гамшгаас хамгаалах "Бэлэн байдлын үзлэг"-ийг зохион байгуулахад гарсан зардалд 2,339,760 (Хоёр сая гурван зуун гучин есөн мянга долоон зуун жар) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 14,371,260 (Арван дөрвөн сая гурван зуун далан нэгэн мянга хоёр зуун жар) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

671 0117 15